



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 40

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Төрийн албаны Зөвлөлийн 2019 оны 59-р тогтоолоор батлагдсан "Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.6.4 дэх заалт, Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Сант сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга нарын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 7036-1111 утсанд ирүүлсэн иргэний гомдол, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд гаргасан өргөдлийг шалгах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга

Э.Оюунболд
(Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга)

Гишүүд

Ш.Энхмаа
(Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Ч.Энхтуяа
(Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Төрийн аудитын газрын дарга)

М.Нямсүрэн
(Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга)

Ч.Даваадорж
(Салбар зөвлөлийн гишүүн, ахмад төрийн албан хаагчийн төлөөлөл)

Хоёр.Өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэж, танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Э.Оюунболд)-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА